

ХОРИО ЦЭЭРИЙН ХЭЛТСИЙН ХҮНСНИЙ, ЧАНАР, СТАНДАРТЫН ХЯНАЛТ ХАРИУЦСАН
ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Ч.ОЮУНЦЭЦЭГИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт арга хэмжээний биелэлт

д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхлэсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
Зорилт 2. Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах							
1.	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	ДЭМБ-аас сэрэмжлүүлсэн хүнсний аюулгүй байдлаар харьяа гаалийн газар хороодын гаалийн улсын байцаагчид хурдан шуурхай мэдээлж, гаалийн хилээр нэвтрүүлэхгүй буцаах үйл ажиллагааг хуулийн дагуу арга хэмжээ авч, шийдвэрлэхэд мэргэжил арга зүйгээр тухай бүр хангаж ажиллана.	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, тохиолдол илэрсэн үед хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.	1. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал Монгол Улсын “Хүн амын хоол тэжээлийн байдал” Үндэсний VI судалгааны үр дүнгээр нийт өрхийн 2.7% хүнсний баталгаат байдал ноцтой алдагдсан, өрхийн иоджуулсан давсны хэрэглээ өмнөх судалгааны үр дүнгээс буурч 47.1%-тай гарсантай холбогдуулан Монгол улсад импортолсон хүнсний иоджуулсан давсны хяналт шалгалтын судалгааг гаргаж холбогдох газарт хүргүүлж ажилласан байна. Үүнд: 2022 онд 4211,0 мян.тн, 3441,8 сая төгрөг, 2023 онд 4379,9 мян.тн, 3674,5 сая төгрөг, 2024 онд 5400,4 мян.тн, 3896,5 сая төгрөгийн иоджуулсан давсыг импортолсон. 2. Хүнсний нэмэлт бүтээгдэхүүн болон хүнс төст бүтээгдэхүүний талаар мэдээлэл бэлтгэн 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр ярилцлага өгч удирдлагаар хянагдсан. 3.Хилийн боомтын хөндлөнгийн хамтарсан үнэлгээний нэвтрэх цэгийн хүрээнд хүнсний чиглэлээр хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний мэдээлээр 11 асуумжийг боловсруулан өгч ажилласан. Хүрсэн үр дүн: Хүнсний аюулгүй байдалтай холбоотой тоон мэдээ, мэдээ мэдээлэл, асуумжийг цаг хугацаанд нь гаргаж удирдлагыг мэдээллээр ханган ажилласан.	2025.01.01 2025.06.10	100

2.	Магадлан шинжилгээний үйл ажиллагаанд хяналт тавих	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1. Хорио цээрийн газар, хороодын 2024 оны лабораторийн шинжилгээнд хамруулсан мэдээг нэгтгэхэд 2 улиралд нийт 532,8 мян.тн, 6.355.978 ширхэг, 54 хайрцаг бараа бүтээгдэхүүнээс 12118 удаа 27,7 мян.кг бараа, бүтээгдэхүүн шинжилгээнд хамруулсан байна. Нийт шинжилгээнд хамрагдсан бараа, бүтээгдэхүүнээс 61946 үзүүлэлтээр шаардлага хангаж, 106 үзүүлэлтээр шаардлага хангаагүй байна. Лабораторийн шинжилгээний төлбөр болох 485,4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн ба Улсын Мал эмнэлгийн лаборатори, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эм шинжлэх лабораторийн шинжилгээнд хамруулсан барааны төлбөр ороогүй болно. Лабораторийн шинжилгээт хяналтад нийт хамрагдсан бүтээгдэхүүний	1.Хяналтын чиглэл бүрээр лабораторийн шинжилгээнд хамрагдсан барааны тоо хэмжээ, үзүүлэлтийн 1 дүгээр тайланг нэгтгэн, удирдлагуудыг мэдээллээр хангаж ажиллана. 2.Лабораторийн шинжилгээгээр эерэг буюу шаардлага хангаагүй гарсан барааны дүнд дүн шинжилгээ хийж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, энэ чиглэлээр газар, хороодыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.	Хорио цээрийн газар, хороодын 2025 оны 2 дугаар улирлын лабораторийн шинжилгээнд хамруулсан мэдээг нэгтгэхэд нийт экспортын хяналтаар 13.6 мян.тн бараа бүтээгдэхүүнээс 369 удаа 698 кг бараа, бүтээгдэхүүн шинжилгээнд хамруулсан байна. Нийт шинжилгээнд хамрагдсан бараа, бүтээгдэхүүнээс 1905 үзүүлэлтээр шаардлага хангаж, шинжилгээний төлбөр болох 13,3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Импортын барааны лабораторийн шинжилгээнд хамруулсан мэдээгээр 658.3 мян.тн бараа бүтээгдэхүүнээс 8924 удаа 18.2 тн бараа, бүтээгдэхүүн шинжилгээнд хамруулахад 50000 үзүүлэлтээр шаардлага хангаж, 60 үзүүлэлтээр шаардлага хангаагүй байна. Шинжилгээний төлбөр болох 608,3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Импортын лабораторийн шинжилгээт хяналтад сонгогдсон барааны /658.3 мян.тн буюу 18.2 тн/ 0,003 хувь дээжийг шинжилсэнээс 50000 үзүүлэлт буюу 99.9 хувь шаардлага хангаж, 60 үзүүлэлт буюу 0.1 хувь нь шаардлага хангахгүй дүнтэй гарсан. Хүрсэн үр дүн: Хорио цээрийн чиглэлээр газар, хороодоос лабораторид шинжилгээнд хамруулсан мэдээг авч чиглэл бүрээр 7 хоног, сар, улирлаар авч нэгтгэн, дүн шинжилгээ хийж удирдлагыг мэдээ мэдээллээр ханган ажилласан.	2025.01.01 2025.06.10	100
----	--	----------------------------	--	--	---	--------------------------	-----

			/532,8 мян.тн буюу 0,03 тн/ 0,06 хувь дээжийг шинжилсэнээс 61946 үзүүлэлт буюу 99.8 хувь шаардлага хангаж,106 үзүүлэлт буюу 0.2 хувь нь шаардлага хангахгүй дүнтэй гарсан. 2. Бараанаас сорьц дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг ХЦХ- ээс дотоод зурвасаар хүргүүлэн, 2024 оны 07 сарын 19-ний өдөр батлагдсан ГЕГ-ын А/422 тоот тушаалд санал тусгагдсан.				
Зорилт 2 Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх							
3	Гадаад худалдааг хөнгөвчлөх хүрээнд хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлэх	Хэрэгжилт гүйцэтгэлээр	- Ажлын хэсэгт тусгагдсаны дагуу хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг барааны төрөл, ангилал, заавал хамрагдах барааны жагсаалтыг гарган хүргүүлэн ажилласан. - Хорио цээрийн үйл ажиллагааг цахимжуулах А/115 ажлын хэсгийн хүрээнд Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдах	1.ГЕГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/115 дугаар тушаалаар батлагдсан Хорио цээрийн хяналтын үйл ажиллагааг цахимжуулах ажлын хэсэг хорио цээрийн хяналтад хамрагдах барааны эрсдэлийн шалгуурыг	1. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний экспорт, импорт, хүнсний нэмэлт нийт 3 зааврыг эцэслэн боловсруулж ахлах болон Хэлтсийн даргаар хянагдсан. 2. Ажлын хэсгийн “гаалийн мэдүүлэг нөхөн бичих талбар”-т хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын мэдээллийг тусгах талаар нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж ажлын хэсэгт хүргүүлсэн. Хүрсэн үр дүн: Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний экспорт, импорт, хүнсний нэмэлт нийт 3 зааврыг боловсруулж, газар хороодын гаалийн улсын байцаагчид туршилтын журмаар ажиллаж байна.	2025.01.01 2025.06.10	100

			барааг шалгах 32 хяналтын хуудсыг цахимжуулахтай холбоотойгоор 9.3.1 хяналтын хуудсыг цахимжуулахтай холбоотойгоор хяналт шалгалт хийх 3 зааврын төсөл боловсруулан ажиллаж байна.	боловсруулж эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж улаан төлөвт шалгагдах барааны тоог бууруулах судалгааг хийж, Эрсдэлийн удирдлагын хэлтэстэй 3 удаагийн уулзалтыг хийж, хорио цээрийн эрсдэлийн шалгуурыг гаалийн эрсдэлийн шалгууртай уялдуулан тооцох программын даалгаврыг боловсруулсан.			
4.	Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1. Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн нийт зөрчлийн тоо 1100 байна. Үүний 194 зөрчил буюу 17.6%-ийг гаалийн хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчид илрүүлж, холбогдох хууль тогтоомжийн дагуу 261.3 сая төгрөгийн торгууль ногдуулан барагдуулсан байна. 2. Гаалийн ерөнхий	1. Улсын хилээр нэвтрүүлж буй хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хийх ажлыг зохион байгуулах, харьяа газар, хороодыг мэргэжлийн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллана.	1. Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, туслах материалын судалгааг 5 жилээр гаргаж холбогдох газарт хүргүүлсэн. Үүнд: Импортоор 2020 онд 531,3 мян/тн, 32,5 мян/л, 552,5 мян. доллар, 2021 онд 688,8 мян/тн, 41,5 мян/л, 800,9 мян.доллар, 2022 онд 491,7 мян/тн, 61,3 мян/л, 153,9 мян.доллар, 2023 онд 538,3 мян/тн, 52,1 мян/л, 856.5 мян.доллар, 2024 онд 716,7 мян/тн, 70,9 мян/л, 1028,3 мян.доллар, 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн байдлаар 170,7 мян/тн, 13,8 мян/л, 281,7 мян.долларын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн импортлогдсон байна. Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг сүүлийн 5 жилээр харьцуулахад 2022 онд хамгийн бага буюу 491,7 мян/тн, 153,9 мян.доллар, 2024 онд хамгийн буюу 716,7 мян/тн, 1028,3 мян.доллар байна. Импортын хүнсний туслах материал: Импортоор 2020 онд 368,9 сая.ширхэг, 707,693.0 мян.ширхэг, 15,2 сая.доллар, 2021 онд 430,7 сая.ширхэг, 245,058.0 мян.ширхэг, 19,5 доллар, 2022	2025.01.01 2025.06.10	100

			газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/676 дугаартай тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан хүснэгтийн дагуу хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын статистик мэдээг сар бүр хүлээн авч, нэгтгэн, нэгдсэн мэдээг Статистик, дүн шинжилгээний хэлтэст тогтоосон хугацаанд хүргүүлж ажилласан. 3.ХЦХ-ийн ГУБ нар 2024 оны хагас жилийн байдлаар хорио цээрийн мэргэжлийн болон бусад чиглэлээр 9 сургалт, мэдээллийн цагт хамрагдсан байна.	2.Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамаарагдах барааны 47 төрлийн цахим зааврыг эцэслэн боловсруулж дуусган, туршилтад бэлтгэнэ. 3.Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалтын үр дүнг сайжруулах зорилгоор холбогдох яам, агентлагаас зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэг, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллана. 4.ХХААХҮЯ-наас зохион байгуулах “Импортлох, экспортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдалд хяналт тавих журам”-ын төслийн	онд 643,7 сая.ширхэг, 350,832.6 мян/ш, 24,8 сая.доллар, 2023 онд 543,8 сая.ширхэг, 184,768.6 мян.ширхэг, 20,5 сая.доллар, 2024 онд 748,3 сая.ширхэг, 336,534.8 мян.ширхэг, 21,0 сая.доллар, 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн байдлаар 249,7 сая.ширхэг, 68,679.7 мян.ширхэг, 6,5 сая.долларын хүнсний туслах материал импортлогдсон байна. Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг сүүлийн 5 жилээр харьцуулахад 2020 онд хамгийн бага буюу 368,956,881.0 ширхэг, 15,290,191.1 доллар, 2024 онд хамгийн буюу 748,360,096.0 ширхэг, 21,076,726.8 доллар байна. 2.Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/676 дугаартай тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан хүснэгтийн дагуу Хорио цээрийн чиглэлийн 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 01 дүгээр сарын 31-ний өдөр хүртэлх статистик мэдээг нэгтгэсэн байна. ✓ Хүснэгт 22 -ийн экспортын мэдээгээр нийт 337 аж ахуйн нэгж, 1 иргэн экспортолсоноос 825 мэдүүлэгээр, ангилалтын тоо хэмжээ нь 21,3 мян.тн, 8 мэдүүлэгээр 105,1 мян.л, 5 мэдүүлэгээр 1354 ширхэг, 6 мэдүүлэгээр 4300 толгой, 2 мэдүүлэгээр 1,3 дм² бараа экспортлогдсон. Нийт экспортлогдсон барааны цэвэр жин 21,7 мян.тн, бохир жин 21,8 мян.тн, 50,8 сая.доллар, 391 автомашинаар, 140 вагоноор, 25 онгоцоор тус тус тээвэрлэгдсэн байна. ✓ Хүснэгт 22 -ийн импортын мэдээгээр нийт 3225 аж ахуйн нэгж, 20 иргэн бараа импортолсоноос 3325 мэдүүлэгээр, ангилалтын тоо хэмжээгээр 72552,8 мян.тн, 156 мэдүүлэгээр 1032,3 мян.литр, 209 мэдүүлэгээр 5.160.513.047 ширхэг, 1 мэдүүлэгээр 1 толгой, 6 мэдүүлэгээр 2318594 тун, 17 мэдүүлэгээр 73590 м³, 17 мэдүүлэгээр 3108374 м³, 3 мэдүүлэгээр 1,5 сая.дм², 1 мэдүүлэгээр 254,5м², 3 мэдүүлэгээр 126,1м³, 3 мэдүүлэгээр 738 хос бараа импортлогдсон. Нийт барааны цэвэр жин 137910,3 мян.тн, бохир жин 141937,8 мян.тн, 46,4 сая.доллар, 482445 автомашинаар, 9552800 чингэлэгээр, 26 тир машинаар, 190 вагоноор, 64 онгоцоор тус тус тээвэрлэгдсэн байна. Хүрсэн үр дүн: Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/676 дугаартай тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан		
--	--	--	--	--	---	--	--

				хэлэлцүүлэгт оролцож, санал өгнө.	хүснэгтийн дагуу хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын статистик мэдээг хүлээн авч, нэгтгэн, нэгдсэн мэдээг Статистик, дүн шинжилгээний хэлтэст тогтоосон хугацаанд хүргүүлж ажилласан.		
5.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр,	1. “Алсын хараа 2050” урт болон дунд хугацааны, Засгийн газрын 2021-2024 оны хөтөлбөр, Гаалийн байгууллагын стратегийн зорилтод хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналттай холбоотой зорилтын биелэлтийг хүнсний чанар, стандартын хяналтын чиглэлээр хэрэгжүүлж ажилласан. 2. Хүнсний чанар, стандартын хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулахтай холбоотойгоор холбогдох албан тушаалтанд санал хүргүүлсэн. 3. Магадлан хийх журамд А/315 өөрчлөлт оруулахтай холбоотойгоор холбогдох албан тушаалтанд 9 санал хүргүүлсэн.	1. Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналттай холбоотой хууль эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулж ажиллана. 4. Хорио цээрийн нэгжүүдээс салбарын хуулиар хяналт тавих зохицуулалттай ч Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн харьяаллаар хариуцлага тооцож чадахгүй байгаа хуулийн зүйл, заалтын саналыг нэгтгэн авч Хуулийн хэлтэст хүргүүлнэ. 6. Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын	1. “Хүнсний тухай” хуульд холбогдох саналыг боловсруулан хүргүүлсэн ба Сангийн яаманд хүргүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан байна. - Нийт ирсэн албан бичиг 67 Албан бичгээр 47 хариу Дотоод зурвасаар 13 хариу 2. ҮАБЗ-ийн аудитын газраас хуралдаж “ХАБ-ыг хянах өнөөгийн тогтолцоо, үр дүн” ажлын хэсэг байгуулагдаж ажлыг хэсэгт холбогдох тайлан мэдээ мэдээллээр хангах үүргийг авч нийт 14 материалыг бэлтгэн цаасар болон цахимаар хүргүүлэн ажилласан. АУДИТ-аар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн биелэлтийг ХЦХ-ийн харицсан аудитын чиглэлийн асуултын дагуу хариултыг боловсруулан хүргүүлж ажилласан байна. Үүнд: Аудитаас өгсөн алдаа, зөрчлийн 5 асуудлын хүрээнд тайлбар, гаргасан шийдвэр, баримтыг гаргаж холбогдох газарт хүргүүлсэн байна. 3. ББӨГГ-ын 2025 оны дотоод төлөвлөгөөнд тусгагдсан сургалтад “Импортын хүнсний бүтээгдэхүүний хяналт, стандартын хэрэгжилт, хорио цээрийн статистик мэдээ, хүнсний бүтээгдэхүүний тээвэрлэлт, шошгололтын тандалт судалгааны заавар” сэдэвээр 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр 10.30-12.50 цаг хүртэл хичээл зааж гаалийн улсын байцаагчдыг мэдлэгийг нэмэгдүүлэх, мэдээ мэдээллэр хангаж ажилласан. 4. Улсын Их Хурлын 2022 онд батлагдсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолын хүрээнд Гаалийн ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/30 дугаартай “Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” тушаалыг боловсруулан батлуулж газар, хороодод чиглэл өгч ажилласан байна. 5. МУИХ-ын С.Лүндэг гишүүнээс ирүүлсэн албан бичгийн хариуг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 02/1714 дугаартай албан бичгээр хүргүүлж хавсралтаар 1. Импортын хүнсний хяналт 17 хуудастай, 2. Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний 5 жилийн тоон мэдээ, 3. Импортын	2025.01.01 2025.06.10	100

				20-ны өдрийн А/676 дугаартай тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан хүснэгтийн дагуу Хорио цээрийн чиглэлийн 2024 оны 12 дугаар сарын статистик мэдээг нэгтгэж, Статистик, дүн шинжилгээний хэлтэст хүргүүлнэ. 7."Хүнсний сүлжээн дэх тээвэрлэлтийн ерөнхий шаардлага" стандартыг хангуулах тандалтын удирдамжийг боловсруулна. 8.Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хаяг шошгололтод тандалт судалгаа хийх удирдамжийг боловсруулна.	хүнсний туслах материалын 5 жилийн тоон мэдээг гаргаж хүргүүлэв. 6. Бүрдүүлэлтийн цахим төвд Хүнсний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3-т "импортлох хүнсний хадгалалтын хугацааны гуравны хоёр нь хүчинтэй байх" гэж заасан заалтад хамаарах хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний БТКУС кодын ангиллын жагсаалтыг бүлэг, зүйл, мөр, үндсэн код, барааны бичиглэлээр гаргаж хавсралтаар 718 барааны жагсаалтыг гаргаж, холбогдох зөвлөгөөг хүргүүлж ажилласан. 7. Азийн хүнс, хөдөө аж ахуйн хамтын ажиллагааны санаачлага (AFACI) байгууллагын санхүүжилттэй "Азийн орнуудын хүнсний найрлагын мэдээллийн санг өргөжүүлэх" олон улсын судалгааны төслийн хэлэлцүүлэгт 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр оролцож холбогдох санал болон хамтран ажиллах боломтой талаар санал өгч оролцсон. 8. ХҮНСНИЙ НЭМЭЛТ /FOOD ADDITIVE/ сэдэвээр гарын авлагын төслийг боловсруулан холбогдох газарт хүргүүлсэн. Хүрсэн үр дүн: Удирдах газруудаас ирсэн албан бичгийн дагуу мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь гаргасан. Гаалийн ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/30 дугаартай "Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай" тушаалыг боловсруулан батлуулж газар, хороодод чиглэл өгч ажилласан.		
--	--	--	--	--	--	--	--

6.	Үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1.Хэлтсийн 7 хоногийн хийсэн ажлын мэдээг гаргаж, удирдлагуудыг мэдээллээр хангаж ажилласан. 4.Төрийн байгууллага болон иргэд, аж ахуй нэгжээс 1111 сувагт ирсэн 4 өргөдөл гомдлыг бүртгэлжүүлж, зохих журмын дагуу хариу өгч шийдвэрлэсэн.	1.Хэлтсийн ажлын мэдээг 7 хоног, сар, жилээр төлөвлөн нэгтэн, тайлагнаж ажиллана. 3.Өргөдөл, гомдлыг хугацаанд нь хуулийн хүрээнд шийдвэрлэхэд хяналт тавьж, Засгийн газрын 1111 сувгаар ирүүлсэн мэдээг нэгтгэж ажиллана .	1. Гаалийн байгууллагын удирдах ажилтны зөвөлгөөнд Хорио цээрийн хяналтын тогтолцоо шийдэлд 3 асуулт, хариултыг бэлтгэж өгсөн. 2. Хэвлэлд “Гаалийн хилээр нэвтэрч буй хүнсний бүтээгдэхүүний хяналт” сэдэвээр мэдээлэл өгсөн. 3. ЗУГ-аас гаргасан хуваарийн дагуу цаг хугацаандаа ХАСХОМ-ийг мэдүүлж баталгаажуулсан. Хэлтсийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газар, хороодоос лабораторийн шинжилгээнд хамруулсан мэдээг 7 хоног, сараар нэгтгэн биелэлтийг гарган удирдлагад хүргүүлсэн. 4. Засгийн газрын 1111 төвөөс хувь хүн будаа импортлож саатуулагдсаны улмаас хилийн хориг тавиулсанаар гомдол гаргасан байна. Ачааны машиныг 3 дугаар сарын 11-ний өдөр хоригийг цуцалсан ба уг иргэний асуудлыг хуульд зааснаар ЗҮГГ эцэслэн шийдвэрлэсэн. 5. Засгийн газрын 1111 төвөөс 2025.05.016. Ёндонжамц Баттулга: /эрэгтэй/ Би сүүлийн 3-4 жил гааль дээрээс авто машин авч байна. Гааль дээр 1 авто машинаас ариутгалын 7000 төгрөг авдаг. Жилдээ 100,000 орчим суудлын автомашин орж ирдэг гэсэн судалгаа байдаг. Тэгвэл жилдээ 700 сая төгрөг болж байна. Энэ мөнгө хаана ордогийг мэдмээр байна. Ариутгал огт хийдэггүй байж мөнгө авч байна. Холбогдох газарт нь уламжилж өгнө үү. Шийдвэрлэлтийн байдал: 2025.05.16. Сангйн сайдын 2025.02.21-ний өдрийн А/36 дугаар тушаалаар 2025 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 00 цагаас эхлэн Улсын хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгсэл, бараа бүтээгдэхүүнд хийгдэх хураамжийг зогсоох тухай харьяа гаалийн газар хороодод 01-1/842 дугаартай “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийг хүргүүлж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Улсын хилээр нэвтрүүлж буй зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, бүтээгдэхүүнээр дамжин Олон улсын эрүүл мэндийн дүрмээр (ОУЭМД 2005) зохицуулагддаг хүний хөл хориот өвчин, мал амьтны гоц халдварт өвчин, ургамлын гадаад хорио цээртэй өвчин, хортон шавьж, хог ургамал, мэрэгч амьтан улсын хилээр нэвтрэх, тархахаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг авах зорилгоор халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлж, төлбөрийн хураамж авахгүй болсон.	2025.01.01 2025.06.10	100
----	---------------------------------------	-------------------------	---	---	--	--------------------------	-----

7.	Албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1.Нэгжийн албан хаагчдын ажлын цаг ашиглалт 100 хувьтай байсан, шалтгаангүй ажил тасалсан албан хаагч байхгүй байна.	1.Нэгжийн албан хаагчдын ажлын цаг ашиглалтад хяналт тавьж, тайлагнана.	Тайлангийн хугацаанд өвчтэй, чөлөөтэй цаг байхгүй ажлын цаг ашиглалт 100%-тай ажилласан байна. Хүрсэн үр дүн: Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, холбогдох албан бичгийн хариуг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн.	2025.01.01 2025.06.10	100
8	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг хангуулах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр,	1.МУ-ын УИХ-ын захирамж, холбогдох тогтоолыг хэрэгжүүлэх 1 ажлын хэсэгт ажилласан.	1.ЗББНДБ болон харьяа гаалийн газар, хороодтой хорио цээрийн хяналтын үйл ажиллагааг уялдуулж ажиллана. 2.МУ-ын УИХ-ын захирамж, холбогдох тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хэсгүүдэд ажиллана. 3.Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээний хүрээнд төрийн болон төрийн бус болон гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллана.	1. ХААИС-тай Гаалийн байгууллага хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд хамтын ажиллагааны хүрээнд 3, 4 дүгээр курсын оюутнуудад “Хүнсний чанар, стандартын тухай ойлголт, хяналтад тавих шаардлага” сэдэвээр 6 цагийн хичээл зааж ажилласан. 2. “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” МУИХ-ын 36 дугаар тогтоолын хэрэгжүүлэх ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн тайланг 2025 оны 04 дүгээр сарын байдлаар гаргаж бэлтгэсэн байна. 3. Гаалийн тухай хуулийн 68 дугаар зүйл, ГЕГ-ын даргын 2025 онй А/19 дүгээр тушаалаар батлагдсан “Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг, МУИС болон ГЕГ-ын хамтын ажиллагааны санамж бичгийг үндэслэн Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний эрх олгох анхан шатны сургалтыг хоёр тал харилцан тохиролцож, зохион байгуулсаны үндсэн дээр 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр хүнсний чиглэлээр 2 цагийн хичээл заасан. Хүрсэн үр дүн: Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, МУИХ-ын 36 дугаар тогтоолын хэрэгжүүлэх ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн тайланг хийж гүйцэтгэсэн.	2025.01.01 2025.06.10	100
Зорилт 3. Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх							
9.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	3.ГЕГ-ын даргын тушаалаар баталсан 1 ажлын хэсэгт ажиллан, хорио цээрийн үйл ажиллагаатай холбоотой холбогдох 5 журам, заавар,	1.Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын чиглэлийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулж	1. СХЗГ-т стандартын шинэ ажлын сэдвийн хүрээнд хүнсний сүлжээн дэх тээвэрлэлтийн ерөнхий шаардлагыг хангуулах зорилгоор “Хүнсний сүлжээн дэх тээвэрлэлтийн ерөнхий шаардлага” стандартын 2025-2026 онд боловсруулахаар төлөвлөгөөнд оруулан ажилласан. 2. ХХААХҮЯ-наас зохион байгуулсан “Импортлох, экспортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдалд хяналт тавих журам”-ын төслийн	2025.01.01 2025.06.10	100

			төлөвлөгөөнд санал өгсөн.	ажиллан, илэрсэн зөрчил дутагдалд дүн шинжилгээ хийнэ. 2.ГЕГ-ын даргын 2019 оны 275 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ыг шинэчлэхэд хорио цээрийн чиглэлэр саналыг өгч ажиллана.	хэлэлцүүлэгт оролцож,санал өгсөн. 3. "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"- д утгыг найруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр заалт нэмэх зэрэг нийт 5 саналыг боловсруулан хүргүүлсэн. 4.Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-д хамтран ажиллаж нийт 32 саналыг боловсруулан, үндэслэл, тайлбарын хамт хүргүүлэв. 5.ХХААХҮЯ-наас зохион байгуулсан "Импортлох, экспортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдалд хяналт тавих журам"-ын төслийн хэлэлцүүлэгт оролцож,санал өгсөн. 6. Хүнсчдийн холбоонд "Хүнсний тухай" хууль"-д өөрчлөлт орох хилээр нэвтрүүлэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнтэй холбоотой саналыг боловсруулж цахим хаягаар хүргүүлсэн. /2/3 заалт/ 6. Хорио цээрийн хяналтын чиглэлээр 2025 оны 05 дугаар сард нийт 33 зөрчил илрүүлж, 20 аж ахуйн нэгж, 13 иргэн холбогдож Гаалийн тухай хуулийн 11.21 дүгээр зүйлийн 11 дэх хэсэг, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6.15 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Зөрчлийн тухай хуулийн 6.15.10 дах заалт, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 11.22 дугаар зүйлийн 6.4 дэх заалт, Эрүүл ахуйн тухай хуулийн 6.17 дугаар зүйлийн 5 дахь заалтыг тус тус зөрчиж, 47,5 сая төгрөгийн тогууль ногдуулж 100 хувь барагдуулсан байна. Нийт зөрчлийг авч үзвэл хүнсний чанар, стандартын хяналт 45,4 хувь, эм, биобэлдмэлийн хяналт 27,3 хувь, мал эмнэлгийн хяналт 18,2 хувь, ургамлын хяналт 6,0 хувь, эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт 3,0 хувийг тус тус эзлэж байна. Хүрсэн үр дүн: Нийт 2 хуулийн 7 заалт, журамд 32 саналыг холбогдох газарт хүргүүлсэн. Хорио цээрийн хяналтын чиглэлээр 2025 оны 05 дугаар сард нийт 33 зөрчил илрүүлж, 20 аж ахуйн нэгж, 13 иргэн холбогдож, холбогдох заалтын дагуу 47,5 сая төгрөгийн торгууль ногдуулж 100 хувь барагдуулсан.		
--	--	--	---------------------------	--	--	--	--

Нэг. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

д/д	Зорилтыг хэрэгжүүлэх	Шалгуур	Гүйцэтгэлийн түвшин
-----	----------------------	---------	---------------------

	арга хэмжээ	үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхлэсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Байгууллагаас зохион байгуулж буй сургалтад хамрагдаж хувь хүний хөгжил, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх	Сургалтад хамрагдсан тоо	Байгууллагаас зохион байгуулсан нийт 9 сургалт, мэдээллийн цагт хамрагдсан.	хувь хүний хөгжил, мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн байх	Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний давтан сургалт” болон байгууллагаас зохион байгуулсан 10 мэдээллийн цагт хамрагдсан. Хүрсэн үр дүн: Байгууллагаас зохион байгуулсан сургалт мэдээллийн цагт хамрагдаж түрүү оны мөн сартай харьцуулахад 10 хувиар илүү биелүүлсэн.	2025.01.01 2025.06.10	100
2	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх	Төрийн албаны тухай, Авлигын эсрэг хууль болон тэдгээрийг даган гарсан журмуудыг уншиж судалсан байна	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд багтаан үнэн зөв мэдүүлсэн.	Журмуудыг судалж, мэдлэг олж авсан байна.	ШУТИС-ийн “Багшлах эрх олгох сургалт” нь сургалтын үйл ажиллагаанд хийх инновацийг хэрэгжүүлэгч, үр өгөөжийг дээшлүүлэх багшийг бэлтгэх зорилготой сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр төгсөж сертификатаа гардан авсан. Хүрсэн үр дүн: ШУТИС-ийн “Багшлах эрх олгох сургалт”-д өөрийн зардлаар суралцаж Багш хүн нийгэмд гүйцэтгэх ёс суртахууны үүргийг сайтар ухамсарласан, ёс суртахууны үнэт зүйлийг өөртөө шингээсэн байх төдийгүй үлгэрлэгч байх гэсэн багшийн ёс зүй, багшлахуйн арга зүйн ойлголтыг олж авах, багшлах үйлээр дамжуулан нийгэмд зөв эерэг үйлийг бий болгоход өөрийн хувь нэмэрээ оролцуулах дадалтай болсон.	2025.01.01 2025.06.10	100

Тайлан гаргасан:

Хүнсний чанар, стандартын хяналт хариуцсан
Гаалийн улсын байцаагч

..... /Ч.Оюунцэцэг/

2025 оны 06 сарын 10 өдөр